



**ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН**

**НИЙТИЙН АЛБАН ТУШААЛТНЫ ХУУЛЬ БУС
ХӨРӨНГИЙГ ХУРААН АВАХ, НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДАГАЛДАХ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭ**

**/ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ/**

2025

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

I сар



Судалгааг захиалагч:

Хууль зүй, дотоод хэргийн яам

Судалгааг хянасан:

Х.Эрдэм-Ундрах

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал,
Хууль зүйн ухааны доктор (Dr.jur)

Судалгааг удирдсан:

М.Түвшинжаргал

Эрдэмтэн нарийн бичгийн дарга,
Хууль зүйн ухааны доктор (Ph.D)

Судалгааг гүйцэтгэсэн:

Б.Ариунжаргал

Эрүүгийн эрх зүй, криминологийн
секторын эрхлэгч, LL.M

Б.Энхжаргал

Эрүүгийн эрх зүй, криминологийн
секторын эрдэм шинжилгээний ажилтан



АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	4
УДИРТГАЛ	5
НЭГ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ	7
ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ НЬ ТООЦОХ ХЭСГЭЭ ТОГТООСОН БАЙДАЛ	8
2.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд	8
2.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал	8
2.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал	9
2.4. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал	9
ГУРАВ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ	10
3.1. “ЗОРИЛГОД ХҮРЭХ БАЙДАЛ” ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭЭР ҮНЭЛСЭН БАЙДАЛ	10
3.1.1. Төсөлд тусгасан гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэхийг үнэлсэн байдал	10
3.2. “ПРАКТИКТ ХЭРЭГЖИХ БОЛОМЖ” ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭЭР ҮНЭЛСЭН БАЙДАЛ	14
3.2.1. Төслийн 18.6 дугаар зүйлд заасан “Мөнгө угаах” гэмт хэргийн зохицуулалтын практикт хэрэгжих боломжийг үнэлсэн байдал	14
3.2.2. Төслийн 17.13 дугаар зүйлд заасан “Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгийг авах, борлуулах” гэмт хэргийн зохицуулалтын практикт хэрэгжих боломжийг үнэлсэн байдал	17
3.3. “ОЙЛГОМЖТОЙ БАЙДАЛ” ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭЭР ҮНЭЛСЭН БАЙДАЛ	19
3.4. “ХАРИЛЦАН УЯЛДАА” ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭЭР ҮНЭЛСЭН БАЙДАЛ	23
ДӨРӨВ.ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ	25
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ	27



ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

НАТХБХХАНТХ

Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах нөхөн төлүүлэх тухай хууль

НҮБ

Нэгдсэн Үндэстний байгууллага

ЭХНӨОтХ

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль

УДИРТГАЛ

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”-ын Зорилго 5-д “...хүний эрхийг бүрэн хангасан, шударга ёсны тогтолцоо төлөвшсөн, авлигагүй улс болно.”¹ гээд Зорилт 5.6-д “Үндэсний шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх замаар авлига, албан тушаалын гэмт хэргийг бууруулна.” хэмээн зааж Зорилтыг хэрэгжүүлэх I үе шат буюу 2021-2030 оны хугацааг “авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх хууль, эрх зүйн болон бодлогын орчин, шударга ёсыг эрхэмлэсэн бүх нийтийн хандлагыг төлөвшүүлэх үе” гэж тодорхойлжээ. Мөн **Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Алсын хараа-2050”** Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа-ны зорилт 5.6-д “Үндэсний шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх замаар авлига, албан тушаалын гэмт хэргийг бууруулна.” гээд тус зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг “Авлига, албан тушаалын гэмт хэрэгт холбогдсон төрийн албан хаагчид оногдуулах хариуцлагыг чангатгаж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх, авлигын хэргийг хянан шалгах, шийдвэрлэхтэй холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно.”² хэмээн заажээ.

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр (2023-2030)”-ийн зорилт 4.3-т “Авлигын улмаас олсон хөрөнгө, орлогыг илрүүлэх, мөнгө угаах эрсдэлийг бууруулж, хуулийн этгээдийн хүлээх үүрэг, хариуцлагын тогтолцоог бэхжүүлнэ.” гээд тус зорилтын 4.3.1-д “Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч, ашиг хүртэгчийн мэдээллийг тогтмол шинэчилж, олон нийтэд нээлттэй болгоно. Мэдээлэл ирүүлээгүй хуулийн этгээдийн хүлээх үүрэг, хариуцлагыг чангатгана.” гэж, Зорилт 6.1-ийн 6.1.4-т “Хөрөнгө буцаасан, хураасан, царцаасан хөрөнгийн удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн орчныг бүрдүүлнэ.”, Зорилт 6.2-т “Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцыг эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх үндэслэл болгон хэрэглэх, эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээг бусад улс оронтой байгуулах ажлыг эрчимжүүлж, дотоодын байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулна.”, Зорилт 6.3-т “Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг гэмт хэрэг үйлдсэн хүн нас барсан, сураггүй алга болсон, оргон зайлснаас үл хамааран шүүхийн шийдвэрээр хурааж, улсын орлого болгох тогтолцоог бүрдүүлнэ.”, Зорилт 6.4-ийн 6.4.1-д “Орлогоосоо давсан зарлагатай, хөрөнгө, орлогын эх үүсвэрээ нотолж чадаагүй албан тушаалтныг нийтийн албанаас чөлөөлөх, эгүүлэн татах эрх зүйн орчныг бүрдүүлнэ.”³ гэж тус тус заасан байна.


Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.2.1-ийн 4.2.1.1-д “Авлига, албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх бодлого, эрх зүйн шинэчлэлийг эрчимжүүлнэ.”, 4.2.1.2-т “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг эрчимжүүлнэ.”⁴ гэж тус тус заажээ.

¹ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=211057&showType=1>

² <https://legalinfo.mn/mn/detail?lawId=211058&showType=1>

³ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16760139806351&showType=1>

⁴ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17141368388631&showType=1>



Дээр дурдсан Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого тэргүүтэй бодлогын баримт бичгүүдэд авлигагүй нийгмийг цогцлоон бүрдүүлэх, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчныг бүрдүүлэх, боловсронгуй болгох, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг шүүхийн шийдвэрээр хурааж, улсын орлого болгох тогтолцоог бий болгох тухай нийтлэг байдлаар заасан байна. Үүнтэй холбоотойгоор Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн А/41 тоот тушаалаар Авлигын эсрэг багц хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг холбогдох байгууллагын төлөөллийг оролцуулан байгуулан ажиллаж энэхүү Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх тухай анхдагч хуулийн төслийг доор дурдсан дагалдах хуулиудын хамтаар боловсруулжээ. Үүнд:

1. Түр болон бүр хураан авсан, царцаасан хөрөнгийг эрхлэн удирдах тухай (Анхдагч хууль);
2. Иргэний хуульд нэмэлт оруулах тухай хууль;
3. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль;
4. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль;
5. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль;
6. Авлигын эсрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль;
7. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль;
8. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль;
9. Төрийн аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль.

Уг төсөлд, Хууль тогтоомжийн тухай хуульд заасныг үндэслэн Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ыг баримтлан хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээг хийж, гүйцэтгэсэн.

Ийнхүү хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээг тооцохдоо Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх тухай анхдагч хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх үнэлгээнээс тусад нь тус хуулийн төслийн дагалдах хуулийн төслүүдийн нэг болох Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөг тооцох нь зүйтэй гэж үзсэн болно.

Учир нь ЭХНӨОтХ-ийн төсөл нь одоогийн Эрүүгийн хуульд заасан зарим төрлийн гэмт хэргийн шинж, бүрэлдэхүүнийг өөрчилж, зарим гэмт хэргийн шинээр хуульчлахаар тусгасан байна. Мөн хууль зүйн нэр томъёоны хувьд өмнө нь Эрүүгийн хууль тусгагдаж байгаагүй шинэ нэр томъёог оруулахаар тусгасан гэх мэт үндэслэл тогтоогдож байх тул дээрх анхдагч хуулийн төслөөс тусад нь ЭХНӨОтХ-ийн төслийн үр нөлөөг нь тооцсон болно.



НЭГ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Энэхүү судалгааны хүрээнд тус хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд дурдсан дараах 4 шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

1. Зорилгод хүрэх байдал
2. Практикт хэрэгжих боломж
3. Ойлгомжтой байдал
4. Харилцан уялдаа

Эдгээр шалгуур үзүүлэлтийг сонгохдоо дараах үндэслэлийг харгалзан үзсэн.

1. Төслийн 1.10 дугаар зүйлийн 11 дэх хэсэгт заасан гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой зохицуулалт болон мөн хуулийн 22.16 дугаар зүйлд заасан “Шүүгч нөлөөллийн мэдүүлэг хөтлөхгүй байх” гэмт хэргийн зохицуулалт Эрүүгийн хууль болон Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх тухай хуулийн төслийн зорилгод хүрсэн эсэх.
2. Төслийн 18.6 дугаар зүйлд заасан “Мөнгө угаах”, мөн хуулийн 17.13 дугаар зүйлд заасан “Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгийг авах, борлуулах” гэмт хэргийн зохицуулалт практикт хэрэгжих боломжтой эсэх.
3. Төслийн нэр томьёо, хэл зүйн найруулга, үг сонголтын хувьд ойлгомжтой байгаа эсэх, иргэд байгууллагууд тухайн зохицуулалтыг шууд ойлгож хэрэглэх, хэрэгжүүлэх ойлгомжтой эсэхийг ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтийн дагуу;
4. Төслийн зүйл, заалт нь өөр хоорондоо болон бусад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжтой нийцсэн эсэх, мөн төрийн байгууллагын чиг үүрэгтэй давхардсан, зөрчилдсөн эсэхийг тус тус үнэлнэ.

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ НЬ ТООЦОХ ХЭСГЭЭ ТОГТООСОН БАЙДАЛ

Энэхүү хэсэгт уг хуулийн төслийн үр нөлөөг нь үнэлэх хэсгийг тогтоож, сонгосон шалгуур үзүүлэлтийн хүрээнд холбогдох зүйл, заалтыг сонгоно. Тус зүйл, заалтыг сонгохдоо хууль зүйн хувьд шууд үр дагавар үүсгэж байгаа голлох ач холбогдол бүхий заалтуудыг сонгосон. Өөрөөр хэлбэл, тухайн төслийн үр нөлөөг үнэлэхдээ цаг хугацаа, зардал хэмнэх үүднээс голлох ач холбогдол бүхий заалтыг сонгож, тухайн сонгосон зүйл, заалтын үр нөлөөг судаллаа.

2.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд

“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр хууль тогтоомжийн төслийн зохицуулалтыг шалгаж, үр нөлөөг нь үнэлэх бол тухайн төслөөр тавьсан зорилгод хүрэхэд чиглэгдсэн эсхүл түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц зүйл, заалтыг сонгоно. Үүний тулд тухайн төслийн үзэл баримтлалтай сайтар танилцаж, хууль тогтоомжийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлагыг хэрхэн тодорхойлсон, энэхүү үндэслэл, шаардлага нь зорилгыг хэрхэн илэрхийлж байгаа эсэхийг судалдаг.

Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх тухай хуулийн төслийн хүрээнд Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал хөндөгдөж байна. ЭХНӨТХ-ийн төслийн үр нөлөөг тусад нь тооцож байгаа боловч тус хуулийн төсөл нь НАТХБХХАНТХ-ийн төсөл болон Эрүүгийн хуулийн 1.1 зүйлд заасан зорилготой тус тус нийцэх нь зүйтэй.

Иймд тус багц хуулийн төслийн зорилго болон Эрүүгийн хуулийн 1.1 дүгээр зүйлд заасан тус хуулийн зорилготой холбогдох хуулийн төслийн зохицуулалтыг сонгон авч “зорилгод хүрэх байдал”-ын үр нөлөөг тооцох болно. Сонгосон зүйл, заалтыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийг тогтоосон байдал

Зорилгод хүрэх байдал	Сонгосон зүйл, заалт
Эрүүгийн хуулийн 1.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Энэ хуулийн зорилго нь Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, Үндсэн хуулийн байгуулал, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд оршино” гэж,	Төслийн 1.10 дугаар зүйлийн 11 дэх хэсэг
НАТХБХХАНТХ-ийн төслийн 1.1-д “Энэ хуулийн зорилго нь нийтийн албан тушаалтны хууль ёсны орлогын эх үүсвэрээс давсан, түүний шууд болон шууд бус өмчлөл, эзэмшилд байгаа, эрхэлж байсан болон эрхэлж байгаа албан тушаалын эрх нөлөөгөөр бий болсон, хууль ёсны эх үүсвэр тодорхойгүй, эсхүл хууль бус аргаар олж авсан эдийн, эдийн бус хөрөнгө, түүний үнэ, түүнээс олсон ашиг, орлогыг хурааж авах, нөхөн төлүүлэх эрх зүйн үндэслэлийг тогтоох замаар нийтийн алба дахь авлигыг таслан зогсоох, дахин үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх, авлигагүй нийтийн албыг бий болгоход оршино” гэж заасан зорилгод хүрч байгаа эсэх	Төслийн 22.16 дугаар зүйл

2.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал



“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд Хүнийг хууль бусаар хорих, Хүнийг хүчээр алга болгох гэмт хэргийн зохицуулалтыг сонгон үр нөлөөг нь тооцох болно. Сонгосон зүйл, заалтыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийг тогтоосон байдал

№	Практикт хэрэгжих боломж	Сонгосон зүйл, заалт
1.	Мөнгө угаах гэмт хэргийн зохицуулалт практикт хэрэгжих боломжтой эсэх.	Төслийн 18.6 дугаар зүйл
2.	Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгийг авах, борлуулах гэмт хэргийн зохицуулалт практикт хэрэгжих боломжтой эсэх.	Төслийн 17.13 дугаар зүйл

2.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийг сонгон авсан тохиолдолд хууль тогтоомжийн төслөөс тодорхой заалтыг, эсхүл бүхэлд нь сонгон авч шалгах боломжтой. Хууль тогтоомжийн төсөлд хэрэглэсэн нэр томьёо, хэл зүйн найруулга, үг сонголтын хувьд ойлгомжтой, иргэд байгууллагууд тухайн зохицуулалтыг шууд ойлгож хэрэглэх, хэрэгжүүлэх боломжтой байгаа эсэхийг шалгаж үнэлнэ. Иймд тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зүйл, заалтад бүхэлд нь дүн шинжилгээ хийж, үр нөлөөг тооцно.

2.4. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар зохицуулалт нэг бүрийн уялдаа холбоог шалгах учир хуулийн төслийн тодорхой заалт, зохицуулалтыг бус тухайн төслийг бүхэлд нь сонгох нь зүйтэй гэж үзлээ. Өөрөөр хэлбэл, харилцан уялдаа шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн зохицуулалт нэг бүрийн уялдаа холбоо, бусад хуультай нийцтэй байдлыг шалгадаг. Иймд тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зүйл, заалтад бүхэлд нь дүн шинжилгээ хийж, үр нөлөөг тооцно.

ГУРАВ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Өмнөх үе шатуудад хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар харуулав:

Хүснэгт 3. Шалгах хэрэгслийг сонгосон байдал

№	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1.	Зорилгод хүрэх байдал	Төслийн 1.10 дугаар зүйлийн 11 дэх хэсэг, 22.16 дугаар зүйл	Зорилгод дүн шинжилгээ хийх.
2.	Практикт хэрэгжих боломж	Төслийн 18.6 дугаар зүйл, 17.13 дугаар зүйл	Төслийн энэхүү зохицуулалтууд практикт хэрэгжих боломжтой эсэхийг судлах.
3.	Ойлгомжтой байдал	Төслийг бүхэлд нь тооцно.	Ойлгомжтой байдлыг судлах, ингэхдээ Хууль тогтоомжийн тухай хууль болон аргачлалд заасан асуулгаар хуулийн төслийг шалгах.
4.	Харилцан уялдаа	Төслийг бүхэлд нь тооцно.	Хуулийн төслийн уялдаа холбоог Хууль тогтоомжийн тухай хууль болон аргачлалд заасан асуулгаар шалгах.

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэллээ.

3.1. “ЗОРИЛГОД ХҮРЭХ БАЙДАЛ” ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭЭР ҮНЭЛСЭН БАЙДАЛ

3.1.1. Төсөлд тусгасан гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэхийг үнэлсэн байдал

Хуулийн төслийн 1.10 дугаар зүйлийн 11 дэх хэсэгт заасан “ Хууль бус хөрөнгөжих, мөнгө угаах гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа гэмт хэрэг үйлдсэн өдрөөс хойш хорин жил байна” гэж заасан нь дээрх зорилгод хүрч байгаа эсэхийг шалгавал.

Үнэлгээ: Эрх зүйн шинжлэх ухаанд хөөн хэлэлцэх хугацааны ойлголт Ромын эрх зүйн үеэс үүсэн бий болж хөгжиж байгаа боловч эрүүгийн эрх зүй дэх гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны ойлголт нь иргэний эрх зүй дэх хөөн хэлэлцэх хугацааны ойлголтоос хожуу бий болсон. Орчин үед эрүүгийн эрх зүй дэх хөөн хэлэлцэх хугацааны эрх зүйн зохицуулалт нь эх газрын бүлийн улс орнуудад түгээмэл хэрэглэгддэг. Харин жишгийн эрх зүйн бүлийн улс орнуудад хөөн хэлэлцэх хугацааг хэрэглэх нь маш хязгаарлагдмал байдаг бөгөөд хуулийн дагуу зөвхөн хүнд гэж тооцогддоггүй хэргүүдэд хэрэглэх боломжтой байдаг.⁵

Эрх зүйн шинжлэх ухааны хөгжлийн явцад Эрүүгийн хуульд тусгагдсан хөөн хэлэлцэх хугацааны ойлголт нь харьцангуй тогтсон ойлголт юм. Хөөн хэлэлцэх хугацааны ойлголт нь эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэлийн нэг болно. Эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх гэдэг нь гэмт хэргийн нийгмийн аюулын хэр хэмжээ болон гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувийн байдлыг харгалзан түүнд хуульд заасан

⁵ Х.Сэлэнгэ, Авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа: Онол, практикийн асуудал, 2024 он, 3-4 дэх тал.

үндэслэлийн дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй байхыг ойлгодог. Эрүүгийн хариуцлагаас чөлөөлж байгаа үндэслэл нь сонгох болон заавал чөлөөлөх гэсэн хоёр төрөлтэй бөгөөд эрүүгийн хариуцлагаас заавал чөлөөлөх үндэслэл нь шүүхээс үл хамааран бий болдог. Улс орнуудын Эрүүгийн хуульд гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа буюу эрүүгийн хариуцлагад татаж болохгүй хугацаа өнгөрсөн тохиолдолд эрүүгийн хариуцлагаас заавал чөлөөлөхөөр заасан байна.⁶

Улс орнууд Эрүүгийн хуульдаа гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа хэзээ эхлэх, түдгэлзэх, үргэлжлүүлэн тоолох, зогсох буюу тасрах, дуусгавар болох болон ямар гэмт хэрэгт хэрэглэхгүй байхыг нарийвчлан зохицуулж байна.⁷ Мөн авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангид заасан хөөн хэлэлцэх хугацааны ерөнхий зориулалтаар зохицуулагдан хэрэгждэг.

Манай улсын хувьд шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлд зааснаар гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг зорчих эрхийг хязгаарлах болон хорих ялын хэмжээнээс хамааруулан тоолохоор хуульчилсан.

Үүнээс авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг нарийвчлан судлан үзвэл:

Хүснэгт 4. Авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа

Зүйл, заалт	Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа
Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	5 жил
Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг	5 жил
Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг	12 жил
Эрүүгийн хуулийн 22.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	5 жил
Эрүүгийн хуулийн 22.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	5 жил
Эрүүгийн хуулийн 22.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг	12 жил
Эрүүгийн хуулийн 22.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг	20 жил
Эрүүгийн хуулийн 22.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	3 жил
Эрүүгийн хуулийн 22.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэг	5 жил
Эрүүгийн хуулийн 22.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэг	3 эсхүл 5 жил
Эрүүгийн хуулийн 22.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	12 жил
Эрүүгийн хуулийн 22.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг	5 жил
Эрүүгийн хуулийн 22.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	5 жил
Эрүүгийн хуулийн 22.7 дугаар зүйлийн 2 дахь хэсэг	5 жил
Эрүүгийн хуулийн 22.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	5 жил
Эрүүгийн хуулийн 22.8 дугаар зүйлийн 2 дахь хэсэг	5 жил
Эрүүгийн хуулийн 22.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	5 жил
Эрүүгийн хуулийн 22.9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг	5 жил
Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	5 жил
Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг	5 жил
Эрүүгийн хуулийн 22.11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	3 жил
Эрүүгийн хуулийн 22.11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг	5 жил
Эрүүгийн хуулийн 22.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	3 жил
Эрүүгийн хуулийн 22.13 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	3 жил

⁶ Мөн тэнд , 4 дэх тал.

⁷ Мөн тэнд.



Монгол Улсад авлигын гэмт хэргийг мөрдөн шалгах, шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаа нь ихээхэн удаашралтай байгаагаас хуульд заасан хөөн хэлэлцэх хугацаа дуусгавар болж, хэргийг хэрэгсэхгүй болгох явдал түгээмэл байгаа нь олон нийтийн шүүмжлэл өртөж байна.⁸ Тиймээс ч авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг нэмэгдүүлэх асуудал хөндөгдсөөр байдаг.

Түүнчлэн, 2022 оны Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт “...Хуулиар халдашгүй байдлыг баталгаажуулсан албан тушаалтны бүрэн эрхийг эрх бүхий байгууллага, албан тушаалтан түдгэлзүүлээгүй бол гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг зогсоож, бүрэн эрх дуусгавар болсны дараа тоолж эхэлнэ...” гэж нэмж хуульчилсан нь халдашгүй бүрэн эрхтэй байх хугацаандаа гэмт хэрэг үйлдсэн албан тушаалтныг үйлдсэн гэмт хэрэгт нь хариуцлага хүлээлгэх боломжийг бий болгож байна. Ийнхүү нэмэлт, өөрчлөлт оруулах болсон шалтгаан нь “...Авлигын эсрэг НҮБ-ын конвенцод нийцүүлэн хуулиар халдашгүй байдлыг баталгаажуулсан албан тушаалтны бүрэн эрхийг эрх бүхий байгууллага, албан тушаалтан түдгэлзүүлээгүй бол гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг зогсоож, бүрэн эрх дуусгавар болсны дараа тоолно гэж заасны дагуу халдашгүй бүрэн эрхээр халхавчлан хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр эрүүгийн хариуцлага хүлээдэггүй, эрүүгийн хариуцлага гарцаагүй байх, шударга ёсны зарчмыг гажуудуулдаг байдлыг халах зорилгоор энэхүү өөрчлөлтийг тусгалаа...”⁹ гэжээ.

Энэ мэт гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой асуудлаар Эрүүгийн хуульд хэд хэдэн удаа нэмэлт, өөрчлөлт оруулж байсан.

Харин энэхүү ЭХНӨОтХ-ийн төсөлд 1.10 дугаар зүйлийн 11 дэх хэсэгт “Хууль бусаар хөрөнгөжих, мөнгө угаах гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа гэмт хэрэг үйлдсэн өдрөөс хойш хорин жил байна” гэж заажээ.

Төслийн 22.10 дугаар зүйлд заасан “Хууль бусаар хөрөнгөжих” гэмт хэрэгт “нийтийн албан тушаалтан хууль ёсны орлогоосоо их хэмжээгээр давсан хөрөнгө, орлогоо хууль ёсны болохыг үндэслэлтэйгээр тайлбарлаж чадаагүй” бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр тусгасан байна. Гэтэл тус гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг 20 жил байхаар хуульчилсны улмаас тухайлбал, хүн өөрийн 18 жилийн өмнөх хууль ёсны дагуу олж авсан хөрөнгийг хууль ёсны болохыг нотлох боломжгүй нөхцөл байдал үүсэж, хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах нөхцөлийг бүрдүүлэх эрсдэлийг бий болгож байна гэж үзэж болох юм.

Түүнчлэн, Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн яллагдагчаар татах хүртэл тоолно” гэж заасны дагуу тухайн хүн Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйлд заасан гэмт хэрэг үйлдсэн болохыг 20 жилийн хугацаанд тогтоож, яллагдагчаар татах асуудал яригдаж байгаа нь маш урт хугацааны асуудал болж байна.

⁸ Х.Сэлэнгэ, Авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа: Онол, практикийн асуудал, 2024 он, 4 дэх тал.

⁹ Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулга, ХЗДХЯ, 2022 он.



Нөгөөтээгүүр, Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйлд заасан гэмт хэргээс илүү нийгмийн хор аюулын шинжтэй авлигын гэмт хэрэг тухайлбал, Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тус зохицуулалтад тусгаагүй хэр нь 22.10 дугаар зүйлийг л авлигын гэмт хэргүүдээс хөөн хэлэлцэх хугацаа 20 жил байхаар хуульчилж байгаа нь учир дутагдалтай байна.

Иймд хуулийн төслийн 1.10 дугаар зүйлийн 11 дэх хэсэгт заасан гэмт хэсэгт заасан гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой зохицуулалт зорилгодоо бүрэн хүрсэн гэж дүгнэх боломжгүй байна.

Түүнчлэн, зарим гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тусгайлан зохицуулах нь ач холбогдолтой байдаг боловч гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тухайлан тогтоохдоо зайлшгүй тогтоох шаардлага байгаа эсэхийг сайтар нягтлан үзэх нь зүйтэй.

3.1.2. Төслийн 22.16 дугаар зүйлд заасан “Шүүгч нөлөөллийн мэдүүлэг хөтлөхгүй байх” гэмт хэргийн зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэхийг үнэлсэн байдал

Төслийн 22.16 дугаар зүйлд “Шүүгч нөлөөллийн мэдүүлэг хөтлөхгүй байх” гэмт хэргийг Эрүүгийн хуульд шинээр хуульчлахаар тусгасан нь зорилгодоо хүрч байгаа эсэхийг үнэлбэл:

Үнэлгээ: Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 45 дугаар зүйлд “Нөлөөллийн мэдүүлэг хөтлөх” зохицуулалтыг тусгасан бөгөөд тус хуулийн 45.8-д “Шүүгч энэ хуулийн 45.1-д заасан нөлөөллийн мэдүүлгээс гадна энэ хуулийн 44.2-т заасан этгээдтэй уулзсан, харилцсан бөгөөд уг этгээд өөрөө, эсхүл бусдаар дамжуулан тухайн шүүгчид аливаа хэлбэрээр нөлөөлсөн, нөлөөлөхөөр оролдсон, үүрэг, чиглэл өгсөн бол энэ талаарх мэдээллийг агуулсан тэмдэглэл үйлдэж, битүүмжлэн Ерөнхий зөвлөлд ажлын гурван өдрийн дотор хүргүүлэх үүрэгтэй” гэж, мөн хуулийн 45.10-т “Энэ хуулийн 45.8-д заасан үүргээ биелүүлээгүй нь шүүгчид сахилгын шийтгэл хүлээлгэх үндэслэл болно” гэж тус тус заажээ.

Түүнчлэн, тус хуулийн 50.1.39-д “энэ хуулийн 45.8-д заасан үүргээ биелүүлээгүй” буюу нөлөөллийн мэдүүлэг хөтлөх үүргээ биелэхгүй байхыг хоригложээ.


Өөрөөр хэлбэл, Монгол Улсын Шүүхийн тухай хуульд зааснаар шүүгч нөлөөллийн мэдүүлэг хөтлөх үүрэгтэй бөгөөд тус үүргээ биелүүлээгүй шүүгчид сахилгын шийтгэл оногдуулахаар байна.

Гэтэл хуулийн төслийн 22.16 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүгч хуульд заасны дагуу нөлөөллийн мэдүүлэг хөтлөөгүй, эсхүл бүрэн бус, худал хөтөлсөн бол нийтийн албанд ажиллах эрхийг хоёр жилээс таван жил хүртэл хугацаагаар хасаж нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж заажээ.

Өөрөөр хэлбэл, хуулийн төсөлд шүүгч нөлөөллийн мэдүүлэг хөтлөөгүй бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр тусгасан нь Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн зохицуулалттай зөрчилдөж байна. Иймд хууль хоорондын харилцан уялдааг хангах зайлшгүй шаардлагатай болох нь харагдаж байна.

Нөгөөтээгүүр, төсөлд “Шүүгч нөлөөллийн мэдүүлэг хөтлөхгүй байх” гэмт хэргийг Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан “Авлигын гэмт хэрэг”-т хамааруулан 22.16 дугаар зүйлд тусгахаар зохицуулсан нь оновчтой эсэх асуудал хөндөгдөж байна.

Түүнчлэн, “Шүүгч нөлөөллийн мэдүүлэг хөтлөхгүй байх” гэмт хэргийг хуульчилснаар Эрүүгийн хууль болон НАТХБХХАНТХ-ийн хуулийн төслийн зорилгод



хүрэхэд чухал ач холбогдолтой зохицуулалт гэхээс илүүтэй шүүгчийн хараат бус байдалд нөлөөлөх зохицуулалт байхыг үгүйсгэхгүй.

Мөн төслийн 22.16 дугаар зүйлд зааснаар “Шүүгч нөлөөллийн мэдүүлэг хөтлөхгүй байх” гэмт хэрэгт:

- Нөлөөллийн мэдүүлэг хөтлөөгүй;
- Нөлөөллийн мэдүүлэг бүрэн бус
- Нөлөөллийн мэдүүлэг худал хөтөлсөн 3 үндэслэлийг хамааруулжээ.

Эдгээр үндэслэлээр шүүгчид нийтийн албанд ажиллах эрхийг хасаж зорчих эрхийг хязгаарлах ял эсхүл хорих ял оногдуулахаар тусгасан нь оновчтой эсэхийг гадаад орны туршлагыг судлан үзэж тодорхойлох нь зүйтэй. Иймд тус зохицуулалтыг зорилгодоо бүрэн хүрээгүй гэж үзлээ.

3.2. “ПРАКТИКТ ХЭРЭГЖИХ БОЛОМЖ” ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭЭР ҮНЭЛСЭН БАЙДАЛ

3.2.1. Төслийн 18.6 дугаар зүйлд заасан “Мөнгө угаах” гэмт хэргийн зохицуулалтын практикт хэрэгжих боломжийг үнэлсэн байдал

Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөө гэдэгт Монгол Улсын Үндсэн хуулийн хоёрдугаар бүлэгт Монгол Улсын иргэнд баталгаатай эдлүүлэхээр заасан үндсэн эрх, эрх чөлөө хамаарна.¹⁰ Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрхийг хамгаалах нэгэн баталгаа нь Эрүүгийн хууль бөгөөд Үндсэн хуулиар хамгаалагдсан хүний эрх, эрх чөлөөг хамгаалж, ямар үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцон эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудлыг зохицуулдаг. Энэ ч утгаараа Эрүүгийн хууль нь бусад хууль тогтоомжоос илүү хүний эрх, эрх чөлөөг хязгаарлаж байдаг хатуу хууль юм.

Нөгөөтээгүүр хүний эрх, эрх чөлөөг хамгийн ихээр хязгаарладаг Эрүүгийн хууль нь эрх зүйн хэм хэмжээний хийдэлтэй байвал энэ нь эргээд нийгэмд сөрөг үр дагаврыг бий болгож, хүний эрхийг хязгаарлах гол хэрэглүүр болж хувирдаг.

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль хэрэгжиж эхэлснээс хойш өнөөдрийг хүртэл маргаан дагуулсаар байгаа эрх зүйн хийдэл бүхий зохицуулалтын нэг нь Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйлд заасан “Мөнгө угаах” гэмт хэрэг юм.

Учир нь Эрүүгийн хуульд тус гэмт хэргийн бүрэлдэхүүн, шинжийг зөв, ойлгомжтой байдлаар тодорхойлоогүйн улмаас практикт энэхүү зохицуулалт үндсэн шийдвэрлэх асуудлаасаа илүүтэй ахуйн хүрээний жижиг харилцааг зохицуулсан зохицуулалт болон хувираад байна.

Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх зорилго нь ахуйн хүрээнд эсхүл хохирол багатай эдийн засгийн гэмт хэргийн халдлагад өртсөн эд зүйлийг хамгаалахад чиглэдэггүй бөгөөд албан тушаал, авлигын бүх төрлийн гэмт хэрэг, татвар төлөхөөс зайлсхийх, хүний наймаа, хууль бус зэвсгийн худалдаа, мансууруулах төрлийн гэмт хэрэг, үндэстэн дамнасан гэмт хэргүүд, терроризм, байгалийн баялагтай холбоотой гэмт хэргээс олсон хууль бус орлого, эдийн болон эдийн бус давуу талыг илрүүлэх, олон улс

¹⁰ Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, ХЭҮК, 2023 он, 453 дахь тал.

болон тухайн улсын эдийн засгийн цэвэр урсгалыг хар зах зээлээс хамгаалж бохир мөнгөний урсгал, нөгөө талаар хууль бус санхүүжилтийг таслан зогсооход чиглэгддэг.¹¹

Энэ ч утгаараа Цагдаагийн байгууллага болон тусгайлан ЭХХШТХ-ийн 6.1 дүгээр зүйлийн 1.2-т заасны дагуу тагнуулын байгууллага өөрсдөө илрүүлсэн тохиолдолд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах эрхтэй байдлаар хуульчилсан нийт 7 төрлийн гэмт хэргийн нэг нь мөнгө угаах гэмт хэрэг юм.

Практикт мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх асуудлаар хууль хяналтын байгууллагууд хамтарсан сургалт, хэлэлцүүлэг олонтоо зохион байгуулдаг бөгөөд энэ нь тус гэмт хэргийн хор уршиг, үр дагавар, ач холбогдлыг илтгэж буй хэрэг юм. Гэтэл шүүхээр шийдвэрлэгдэж буй мөнгө угаах гэмт хэргийн дийлэнх нь хулгайн эд зүйлийг зарж борлуулсан, гээгдэл эд хөрөнгө завшсан эд зүйлийг ашигласан, зарж борлуулсан зэрэг хохирлын хэмжээ багатай хэргүүд байгаа нь өөр төрлийн гэмт хэргийг мөнгө угаах гэмт хэргийн тодорхойлолттой хольж хуульчилснаас үүдэн Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйлд заасан зохицуулалт өнөөдөр практикт хэрэгжүүлэхэд асуудалтай маргаан бүхий асуудлын нэг болоод байна.

Учир нь тус гэмт хэргийг хэлбэрийн бүрэлдэхүүнтэй байхаар хуульчилснаас хохирлын хэмжээнээс үл хамаарч эрүүгийн хариуцлага хүлээх үндэслэл болж байна. Тухайлбал,

Тохиолдол 1.

“Э” нь 2021 оны 07 дугаар сарын 10-ны өдөр Өмнөговь аймгийн ... нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулах “Марал” хүнсний дэлгүүрээс худалдан авалт хийхдээ хохирогч “Б”-гийн лангуун дээр мартаж орхисон “Samsung 10S” загварын гар утсыг бусдын эзэмшлийнх болохыг мэдсээр байж хууль бусаар авч, нөхөр “С”-д өгч захиран зарцуулах боломжийг бүрдүүлж, хохирогч “Б”-д 400,000 төгрөгийн хохирол учруулсан буюу гээгдэл эд хөрөнгө завшсан гэмт хэрэгт, Шүүгдэгч “С” нь “Samsung 10S” загварын гар утсыг гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө болохыг мэдсээр байж авч, өөрийн эзэмшлийн Юнителийн дугаарын сим картыг хийн 2021 оны 07 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн захиран зарцуулж, хохирогч “Б”-д 400,000 төгрөгийн хохирол учруулсан буюу мөнгө угаах гэмт хэрэгт тус тус холбогджээ.

Шүүхээс “С”-ийг мөнгө угаах гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцон, 6 сар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэсэн. “Э”, “С” хоёр нь эхнэр, нөхөр бөгөөд эхнэрийнхээ олсон утсыг ашигласны улмаас Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйлийн 1-д заасан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцогдон эрүүгийн хариуцлага хүлээсэн.

Практикт шийдвэрлэгдэж буй Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэрэгт холбогдож, ял шийтгүүлж буй ихэнх тохиолдол хохирлын хэмжээ бага ч “...гэмт хэрэг үйлдэж олсон гэдгийг мэдсээр байж...” гэх үндэслэлд хамааран мөнгө угаах гэмт хэрэг үйлдсэн хэмээн үзэхэд хүргэж байна.

Мөнгө угаах гэмт хэрэг нь үндэстэн дамнасан шинжтэй, далд хэлбэрээр үйлдэгддэг учраас илрүүлэхэд төвөгтэй, хэд хэдэн улсын нутаг дэвсгэр дамжин, аливаа улсын аюулгүй байдал, нийгэм, эдийн засагт их хэмжээний хохирол учруулдаг төдийгүй гэмт хэрэг үйлдэж олсон ашиг, орлогоо хууль ёсны болгож харагдуулахыг зорьдог зэргийг харгалзан мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргийг зөв тодорхойлж, ахуйн шинжтэй, нийгмийн хор аюул бага гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого

¹¹ Б.Өнөрмаа, Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн зохицуулалт нийтлэл, 2017 он, www.mglbar.mn/news/1918, Сүүлд үзсэн: 2022.04.25.

гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласан зэрэг үйлдлийг Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйлд заасан “Мөнгө угаах” гэмт хэргээс ялган зааглах шаардлагатай байсаар байна.

Хуулийн төслийн 18.6-д “Мөнгө угаах” гэмт хэргийн дараах байдлаар өөрчлөн найруулахаар тусгасан байна.

18.6 дугаар зүйл. Мөнгө угаах

1. Энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг хоёр жилээс дээш хугацаагаар тогтоосон, эсхүл энэ хуулийн 18, 20, 22, 25, 26, 29 дүгээр **бүлэгт**¹² заасан гэмт хэрэг, эсхүл гадаад улсад үйлдэгдсэн бөгөөд гадаад улсын хуулиар хоёр жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогоо ашигласан, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогынхоо эх үүсвэр, шинж чанар, байршил захиран зарцуулах арга, өмчлөгч, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг өөрчилсөн, шилжүүлсэн, нуун далдалсан бол зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2. Бусдын үйлдсэн буюу энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг хоёр жилээс дээш хугацаагаар тогтоосон, эсхүл энэ хуулийн 18, 20, 22, 25, 26, 29 дүгээр бүлэгт заасан гэмт хэрэг, эсхүл гадаад улсад үйлдэгдсэн бөгөөд гадаад улсын хуулиар хоёр жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласан, эсхүл түүний эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлсэн, эсхүл түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эд хөрөнгийн эрх, өмчлөгч, эзэмшигчийг нуун далдалсан бол зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3. Энэ гэмт хэргийг:

3.1. энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг таван жилээс дээш хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого болохыг мэдсээр байж;

3.2. виртуал хөрөнгө ашиглаж;

3.3. хуулийн этгээдийг халхавчаар ашиглаж;

3.4. үндэстэн дамнаж;

3.5. байнга тогтвортой үйлдэж;

3.6. албан тушаалтан албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашиглаж үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

4. Энэ гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

5. Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж нэг зуун хорин мянган нэгжээс дөрвөн зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

- Энэ зүйлийн 3 дахь хэсгийн 3.7-д заасан “үндэстэн дамнаж” гэдэгт дараах тохиолдлыг ойлгоно:

- энэ гэмт хэргийг хил дамнуулан үйлдсэн бол;

- энэ гэмт хэргийг нэг улсад үйлдсэн боловч тухайн гэмт хэрэгт бэлтгэх, төлөвлөх, удирдан зохион байгуулах, хянах үйлдлийг өөр улсад хийсэн бол;

- энэ гэмт хэргийг нэг улсад үйлдсэн боловч тухайн гэмт хэргийг үйлдэхэд оролцсон зохион байгуулалттай гэмт бүлэглэл 2 буюу түүнээс дээш улс оронд гэмт хэргийн шинжтэй ажиллагаанд оролцдог бол;

- гэмт хэргийг нэг улсад үйлдсэн боловч бодит үр дагавар нь өөр улсад илэрсэн бол.”

Дээрх зохицуулалттай холбоотойгоор дараах хэд хэдэн асуудал үүсэж болох юм.

1. Хорих ялын доод хэмжээ хоёр жилээс дээш хугацаагаар тогтоосон зарим гэмт хэргийн ахуйн шинжтэй байгааг харгалзан үзэх нь зүйтэй. Учир нь ахуйн шинжтэй гэмт

¹² Хуулийн төсөлд “зүйлд” гэснийг “бүлэгт” гэж өөрчлөн бичсэн болно.

хэргийн мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэрэгт оруулснаар эрх зүйн хийдэлтэй байгаа одоогийн нөхцөл байдал бүрэн засагдахгүй орхигдоно.

2. Эрүүгийн хуулийн зарим бүлгийн тухайлан “Мөнгө угаах” гэмт хэргийн суурь гэмт хэрэг байхаар тусгаж байгаа нь учир дутагдалтай байна. Тухайлбал,

- Эрүүгийн хуулийн 18 дугаар бүлэг “Эдийн засгийн эсрэг гэмт хэрэг”
- Эрүүгийн хуулийн 20 дугаар бүлэг “Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг”
- Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэг “Авлигын гэмт хэрэг”
- Эрүүгийн хуулийн 25 дугаар бүлэг “Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг”
- Эрүүгийн хуулийн 26 дугаар бүлэг “Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг”
- Эрүүгийн хуулийн 29 дүгээр бүлэг “Хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг” тус тус хамаарч байх бөгөөд эдгээр бүлэгт заасан зарим гэмт хэргийн хувьд “Мөнгө угаах” гэмт хэргийн суурь гэмт хэрэгт хамааруулахад тохиромжгүй гэмт хэргүүд байна.

Нөгөөтээгүүр, Эрүүгийн хуулиас дээр дурдагдаагүй үлдсэн бүлгүүдэд “Мөнгө угаах” гэмт хэргийн суурь гэмт хэрэг гэж тусгах шаардлагатай гэмт хэргүүд багтсан байна. Энэ мэтчилэн хуулийн төслийн энэхүү зохицуулалтад засаж сайжруулах асуудлууд байна.


Хуулийн төслийн дээрх зохицуулалт нь одоогийн Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйлд заасан “Мөнгө угаах” гэмт хэргийн эрх зүйн зохицуулалтын хийдлийг арилгахад чиглэсэн зохицуулалт мөн боловч дээр дурдсан асуудлууд хөндөгдөж байгааг дурдах нь зүйтэй.

3.2.2. Төслийн 17.13 дугаар зүйлд заасан “Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгийг авах, борлуулах” гэмт хэргийн зохицуулалтын практикт хэрэгжих боломжийг үнэлсэн байдал

2002 оны Эрүүгийн хуулийн 155 дугаар зүйлд “Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгийг авах, борлуулах” гэмт хэргийг хуульчилсан байсан бөгөөд шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулиар тус зохицуулалтыг 18.6 дугаар зүйлд заасан “Мөнгө угаах” гэмт хэрэгт хамааруулан хуульчилсан.

Хүснэгт 5. 2002 оны Эрүүгийн хууль болон Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн зохицуулалт

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль	2002 оны Эрүүгийн хууль
18.6 дугаар зүйл. Мөнгө угаах 1.Гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласан; түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлсэн; түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	155 дугаар зүйл. Гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгийг авах, борлуулах 155.1.Гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгө гэдгийг мэдсээр байж урьдчилан амлалгүйгээр авсан, хадгалсан, борлуулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.



2002 оны Эрүүгийн хуулийн 155 дугаар зүйлд заасан “Гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгийг авах, борлуулах”, мөн хуулийн 166¹ дүгээр зүйлд заасан “Мөнгө угаах”, мөн хуулийн 162 дугаар зүйлд заасан “Үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа эрхлэх нэрээр халхавчлан хууль бус үйл ажиллагаа явуулах” гэмт хэргийн зохицуулалтуудыг нэгтгэж, Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйлд заасан “Мөнгө угаах” гэмт хэргийг тодорхойлсон байдаг.

Энэхүү судалгааны 3.2.1-д дурдсанчлан “Мөнгө угаах” гэмт хэргийн суурь гэмт хэргийг тодорхойлоогүйгээс Эрүүгийн хуульд заасан бүх төрлийн гэмт хэрэг хэрэг тэр дундаа ахуйн шинжтэй үйлдэгддэг гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж буюу 2002 оны Эрүүгийн хуулийн 155 дугаар зүйлд заасан “Гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгийг авах, борлуулах” гэмт хэрэгт заасан үйлдлийг хийсэн нь шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйлд заасан “Мөнгө угаах” гэмт хэрэгт тооцогдож, эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл болж байна.

Харин хуулийн төсөлд “Мөнгө угаах”, “Гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгийг авах, борлуулах” гэмт хэргийг тусад нь ялган зааглаж тусгасан нь одоогийн практикт тулгамдаж буй дээрх асуудлыг шийдвэрлэхийг зорьсон зохицуулалт болсон байна.

Иймээс төслийн 17.13 дугаар зүйлд заасан “Гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгийг авах, борлуулах” гэмт хэргийн зохицуулалт практикт хэрэгжих боломжтой гэж үзэж байна. Гэсэн хэдий ч хуулийн төслийн тус гэмт хэргийн зохицуулалтыг сайжруулах шаардлагатай. Тухайлбал, хуулийн төслийн 17.13 дугаар зүйлд “Гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгийг авах борлуулах” гэж тусгасан боловч 17.13 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “...Гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгө гэдгийг мэдсээр байж урьдчилан амлалгүйгээр авсан, **хадгалсан**, борлуулсан бол...” гэж заажээ. Өөрөөр хэлбэл, тус гэмт хэрэгт хадгалсан үйлдлийг хамааруулан тооцох эсэхийг тодорхой болгох, мөн гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгө гэдгийг мэдсээр байж хийсэн өөр үйлдлийг энэ гэмт хэрэгт хамааруулан тооцох шаардлагатай эсэхийг судлан үзэх нь зүйтэй.

3.3. “ОЙЛГОМЖТОЙ БАЙДАЛ” ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭЭР ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зүйл, заалт нь найруулга, хэл зүйн болон агуулгын хувьд ойлгомжтой байдлаар томъёологдсон эсэх мөн логик дараалалтай боловсруулагдсан эсэхийг шалгах шаардлагатай. Мөн хууль тогтоомжийн тухай хуулийн 4 дүгээр бүлэгт заасан “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-ийг баримталсан эсэхийг тусгайлан шалгана. Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд дүн шинжилгээ хийлээ.

Хуулийн төслийн зохицуулалт нь хэрэгжүүлэх, хэрэглэх этгээдүүдэд ойлгомжтой байдлаар томъёологдсон эсэхэд дараах байдлаар дүн шинжилгээ хийсэн болно.

Хүснэгт 6. Хуулийн төслийн зохицуулалт ойлгомжтой эсэхэд хийсэн дүн шинжилгээ

№	Ойлгомжгүй байгаа хуулийн төслийн зохицуулалт	Тайлбар	Санал
1.	Төслийн 1.10 дугаар зүйлийн 12 дахь хэсэг	Төслийн 1 дүгээр зүйлд “Эрүүгийн хуульд дор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалтыг нэмсүгэй” гэсний дараа 1/ 1.10 дугаар зүйлийн 11, 12 дахь хэсэг гэсэн боловч тус хуулийн төсөлд 1.10 дугаар зүйлийн 11 дэх хэсгийн тусгасан бөгөөд 1.10 дугаар зүйлийн 12 дахь хэсгийг тусгаагүй байна.	Иймд дээрх зохицуулалтын “12 дахь хэсэг” гэснийг хасаж, “1.10 дугаар зүйлийн 11 дэх хэсэг” гэх.
2.	Төслийн 17.13 дугаар зүйл	Төсөлд 17.13 дугаар зүйл “Гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгийг авах, борлуулах” ¹³ гэж тусгасан боловч тус зохицуулалтыг агуулгыг үзвэл, гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгө гэдгийг мэдсээр байж урьдчилан амлахгүйгээр авсан, хадгалсан, борлуулсан үйлдлийг хамааруулж тодорхойлжээ. Өөрөөр хэлбэл, тухайн зүйлийн нэрд “хадгалах” үйлдлийг оруулаагүй орхигдуулсан байна.	Иймд 17.13 дугаар зүйлийг “Гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгийг авах, хадгалах, борлуулах” гэж өөрчлөх.
3.	Төслийн 22.15 дугаар зүйл	Төслийн 22.15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “... зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж заасан нь тус гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тогтооход асуудал үүсгэхээр байна. Учир нь гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг зорчих	Тус гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа зорчих эрхийг хязгаарлах ял болон хорих ялын хэмжээнээс хамаарч 1 эсхүл 3 жил байхаар байгаа нь ойлгомжгүй байдлыг бий болгож байна. Иймд тус

¹³ Хуулийн төсөлд 17.13 дугаар зүйлийг Эрүүгийн хуульд нэмж хуульчлахаар тусгасан боловч тус зохицуулалт нь 2002 оны Эрүүгийн хуулийн 155 дугаар зүйлд заасан гэмт хэрэг юм. Өөрөөр хэлбэл, 2002 оны Эрүүгийн хуулийн 155 дугаар зүйлд заасан “Гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгийг авах, борлуулах” гэмт хэргийг Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйлд заасан “Мөнгө угаах” гэмт хэрэгт хамааруулан хуульчилсан.

		эрхийг хязгаарлах ял, хорих ялын хэмжээнээс хамааруулан тоолдог. Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1.1.-д “энэ хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг нэг жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон, эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын дээд хэмжээг нэг жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш нэг жил өнгөрсөн; Мөн зүйлийн 1.5-д “энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг зургаан сараас дээш, дээд хэмжээг гурван жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон, эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээг зургаан сараас дээш, дээд хэмжээг гурван жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш гурван жил өнгөрсөн” бол яллагдагчаар татаж болохгүй байхаар хуульчилсан. Гэтэл тус гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг зорчих эрхийг хязгаарлах ялын хэмжээнээс хамааруулан тогтоовол 1 жил, хорих ялын хэмжээнээс хамааруулан тогтоовол 3 жил байхаар байна.	зохицуулалтын засаж сайжруулах буюу гэмт хэрэг оногдуулах зорчих эрхийг хязгаарлах ял боон хорих ялын хэмжээг өөр хооронд нь уялдуулах шаардлагатай.
4.	Төслийн 2 дугаар зүйл	Төслийн 2 дугаар зүйлд “...энэ хуульд заасан нөхцөл болзлыг хангасан тохиолдолд...” гэж тусгажээ. Тус зохицуулалтын “...нөхцөл, болзлыг...” гэж ойлголтоос харвал хуульд тусгайлан болзол заасан мэт харагдаж байна.	Иймд тус зохицуулалтын “...нөхцөл, болзлыг...” гэснийг өөрчлөх.
5.	Төслийн 22.15 дугаар зүйлийн 2 дахь хэсэг	Төслийн 22.15 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “...зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж заажээ. Тус зохицуулалтын зорчих эрхийг хязгаарлах ял, хорих ялын доод хэмжээ ижил боловч ялын дээд хэмжээ нь өөр байна. Энэ нь тус гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тоолоход асуудал маргаан үүсгэж болох юм. Нөгөөтээгүүр, Эрүүгийн хуульд заасан хамгийн хүнд ял нь хорих ял хэр нь энэ гэмт хэргийн зорчих эрхийг хязгаарлах ялын дээд хэмжээ нь хорих ялын дээд хэмжээнээс бага байгаа нь ойлгомжгүй байна.	Иймд тус зохицуулалтын зорчих эрхийг хязгаарлах болон хорих ялын дээд хэмжээг нэг мөр болгох нь зүйтэй.
6.	Төслийн 22.16 дугаар зүйл	Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан “Авлигын гэмт хэрэг”-т хамааруулан төслийн 22.16 дугаар зүйлд “Шүүгч нөлөөллийн мэдүүлэг хөтлөхгүй байх” гэмт хэргийг шинээр тусгасан байна. Шүүгч нөлөөллийн мэдүүлэг хөтлөхгүй байх нь Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан “Авлигын гэмт хэрэг”-т хамаарахаас	

		илүүтэй бусад бүлэгт заасан гэмт хэрэгт хамааруулан хуульчлах нь оновчтой эсэхийг нягтлан үзэх нь зүйтэй.	
7.	Төслийн 7.5 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсэг	Төслийн 7.5 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсэгт “... Түр хураасан, хураан авсан , царцаасан хөрөнгийг эрхлэн удирдах тухай хуульд...” гэж заажээ. Тус зохицуулалтад заасан дээрх хууль нь “Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх тухай” хуулийн төслийг дагалдах 9 хуулийн төслийн нэг болох “ Түр болон бүр хураан авсан царцаасан хөрөнгийг эрхлэн удирдах тухай хууль” байна. Гэтэл төслийн 7.5 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсэгт тус хуулийн төслийн нэрийг ялгамжтай байдлаар бичсэн байна.	Иймд тус зохицуулалтад тусгасан хуулийн төслийн нэрийг дагалдах хуулийн төслийн нэртэй ижил байдлаар тусгах нь зүйтэй.
8.	Төслийн 18.6 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг	Төслийн 18.6 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт “... энэ хуулийн 18, 20, 22, 25, 26, 29 дүгээр зүйлд заасан гэмт хэрэг...” гэсэн нь ойлгомжгүй байдлыг бий болгож байна. Учир нь Эрүүгийн хуульд 18, 20, 22, 25, 26, 29 дүгээр зүйл байхгүй бөгөөд тус зохицуулалтын агуулгаас үзвэл дээрх бүлгүүдийн гэмт хэргийг Мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэрэгт хамааруулсан гэж харагдаж байна.	Иймд тус зохицуулалтын “...18, 20, 22, 25, 26, 29 дүгээр зүйлд заасан гэмт хэрэг...” гэснийг “...18, 20, 22, 25, 26, 29 дүгээр бүлэгт заасан гэмт хэрэг...” гэж өөрчлөх.
9.	Төслийн 22.1 дүгээр зүйл	Төслийн 22.1 дүгээр зүйлд “Албан тушаалын эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах” гэж заажээ. Тус зохицуулалтыг зүйлийн нэр зайлшгүй өөрчлөх шаардлага байгаа эсэх.	Төслийн 22.1 дүгээр зүйл “ Албан тушаалын эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах” гэмт хэргийг одоогийн 22.1 дүгээр зүйл буюу “Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах” гэмт хэрэг гэх нэр томъёогоор нь хэвээр үлдээх, албан тушаалын эрх мэдэл гэж заавал тусгах шаардлагатай эсэхийг судлан үзэх нь зүйтэй.
10.	Төслийн 22.10 дугаар зүйлийн тайлбар	Төслийн 22.10 дугаар зүйлийн тайлбар хэсэгт “...энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан “их хэмжээ” гэдэгт нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс дээш хэмжээг ойлгоно...” гэж заажээ.	Тус зүйлд тусгасан нэг зуун нэгж нь 100.000 төгрөгтэй тэнцэх бөгөөд “их хэмжээний хохирол” гэдгийг 100.000 төгрөг гэж ойлгох боломжгүй. Иймд тус зохицуулалтыг Эрүүгийн хуулийн 2.5 дугаар зүйлийн 4.1-д заасантай уялдуулан

			хохирлын хэмжээгээ тодорхойлох нь зүйтэй.
11.	Төслийн 18.6 дугаар зүйл	Төслийн 18.6 дугаар зүйлд "...Энэ зүйлийн 3 дэх хэсгийн 3.7-д заасан "үндэстэн дамнаж" гэдэгт дараах тохиолдлыг ойлгоно..." тайлбарлажээ.	Тус зохицуулалтад "3 дэх" гэж алдаатай бичигдсэн үгийг "3 дахь" гэж засах.

Мөн дээрх зохицуулалтуудаас гадна хуулийн төслийн 22.15 дугаар зүйлд заасан "Нийтийн албан тушаалтан албан үүрэгтээ хайнга хандах" гэмт хэргийн зохицуулалтыг шалган үзэхэд:

Хүснэгт 7. Шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль болон хуулийн төслийн зохицуулалт

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль	Хуулийн төсөл
23.5 дугаар зүйл.Хайнга хандах 1.Албан тушаалтан хууль, захиргааны хэм хэмжээний актаар тодорхойлогдсон албан үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйн улмаас бусдад их хэмжээний хохирол учирсан бол нийтийн албанд томилогдох, эсхүл сонгогдох эрхийг хоёр жил хүртэл хугацаагаар хасаж хоёр мянга долоон зуун нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 2.Хууль сахиулагч, эмнэлгийн ажилтан шуурхай, яаралтай тусламж үйлчилгээ үзүүлэх албаны ажилтан үүргээ биелүүлээгүйн улмаас хүний амь нас хохирсон, бусдад их хэмжээний хохирол учирсан бол хоёр жил хүртэл хугацаагаар мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	22.15 дугаар зүйл. Нийтийн албан тушаалтан албан үүрэгтээ хайнга хандах 1. Нийтийн албан тушаалтан хууль, захиргааны хэм хэмжээний актаар тодорхойлогдсон албан үүргээ болгоомжгүйгээр биелүүлээгүй, эсхүл зохих ёсоор биелүүлээгүйн улмаас бусдад их хэмжээний хохирол учирсан бол нийтийн албанд ажиллах эрхийг хоёр жил хүртэл хугацаагаар хасаж хоёр мянга долоон зуун нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 2. Энэ гэмт хэргийн улмаас хүний амь нас хохирсон бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар нийтийн албанд ажиллах эрхийг хоёр жилээс таван жил хүртэл хугацаагаар хасаж нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
Эрүүгийн хуулийн 23 дугаар бүлэгт заасан "Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг"-т хамаарч буй "Хайнга хандах" гэмт хэргийн зохицуулалтыг хуулийн төсөлд Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан "Авлигын гэмт хэрэг"-т хамааруулан 22.15 дугаар зүйлд дээрх өөрчлөлтийг оруулж, нэмж хуульчлахаар тусгажээ. Хуулийн төслийн дээрх зохицуулалтаас үүдэн хэдэн хэдэн асуудал бий болж байна. Тухайлбал, тус зохицуулалтыг Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан "Авлигын гэмт хэрэг"-т хамааруулан хуульчлах нь зөв эсэх. Эрүүгийн хуулийн 23.5 дугаар зүйлд заасан "Хайнга хандах" гэмт хэргийг "Авлигын гэмт хэрэг"-т хамааруулах шаардлага байгаа эсэх, олон улсын гэрээ, конвенцод тусгасан авлигын гэмт хэргийн шинжийг тус гэмт хэрэг нь хангаж байгаа эсэхийг нягтлан үзэх нь зүйтэй. Нөгөөтээгүүр, хуулийн төсөлд заасны дагуу 22.15 дугаар зүйлд тус гэмт хэргийн зохицуулалтыг нэмж хуульчилснаар, одоогийн Эрүүгийн хуулийн 23.5 дугаар зүйлийг хасахаар тусгажээ. Энэ нь 23.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийн хувьд хуулийн төслийн 22.15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зохицуулалтын агуулгатай төстэй бөгөөд харин тус зүйлийн 2 дахь	

хэсэгт заасан зохицуулалт нь Эрүүгийн хуулийн 23.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан гэмт хэргийн зохицуулалтаас “Хууль сахиулагч, эмнэлгийн ажилтан шуурхай, яаралтай тусламж үйлчилгээ үзүүлэх албаны ажилтан үүргээ биелүүлээгүйн улмаас.... бусдад их хэмжээний хохирол учирсан...” үйлдлийг хассанаар эдгээр ажилтны дээрх үйлдлийг эрүүгүйжүүлсэн гэж үзэж болох юм.

Өөрөөр хэлбэл, Хууль сахиулагч, эмнэлгийн ажилтан шуурхай, яаралтай тусламж үйлчилгээ үзүүлэх албаны ажилтны хайнга хандсан үйлдэл, эс үйлдэхүйд эрүүгийн хариуцлага хүлээх үндэслэлгүй болох юм.

Төслийн 22.15 дугаар зүйлд “Нийтийн албан тушаалтан албан үүрэгтээ хайнга хандах” гэмт хэргийг тусгажээ. Тус зохицуулалт нь одоогийн Эрүүгийн хуулийн 23.5 дугаар зүйлд заасан “Хайнга хандах” гэмт хэргийн шинжийг агуулж байна.

Эрүүгийн хуулийн 23 дугаар бүлэг “Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг”-т хамаарч байгаа 23.5 дугаар зүйлд заасан “Хайнга хандах” гэмт хэргийг Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэг “Авлигын гэмт хэрэг”-т хамааруулах нь оновчтой эсэхийг сайтар нягтлан үзэх нь зүйтэй.

3.4. “ХАРИЛЦАН УЯЛДАА” ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭЭР ҮНЭЛСЭН БАЙДАЛ

“Харилцан уялдаа” гэсэн шалгуурын хүрээнд хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар зохицуулалт нэг бүрийн уялдаа холбоог шалгах учраас шалгах хэсгээ сонгохдоо хуулийн төслийн тодорхой заалт, зохицуулалтыг бус тухайн төслийг бүхэлд нь сонгох нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, харилцан уялдаа гэсэн шалгуурын хүрээнд зохицуулалт бүрийн уялдаа холбоо, бусад хуультай нийцтэй байдлыг шалгана. Түүнчлэн, хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан дараах асуудлыг тодорхойлох байдлаар төслийн харилцан уялдаатай байдлыг үнэллээ.

Хүснэгт 8. Харилцан уялдаатай эсэхийг үнэлсэн байдал.

Аргачлалд заасан асуулт	Хуулийн төслийг үнэлсэн байдал
Хуулийн төслийн нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх,	Хуулийн төслийн нэр нь Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай бөгөөд энэ нь тухайн зохицуулж буй харилцаандаа хамааралтай байна.
Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх	- Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.8-д “...үндэслэлгүйгээр хөрөнгөжих...” гэж заасан бөгөөд хуулийн төсөлд одоогийн Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйлд заасан “Үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэмт хэргийг “Хууль бусаар хөрөнгөжих” болгон өөрчилж байгаатай холбоотойгоор бусад хуульд заасан “Үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэх нэр томъёог “Хууль бусаар хөрөнгөжих” гэж өөрчлөх эсэх нь тодорхойгүй байна. - Эрүүгийн хуульд “нийтийн албанд ажиллах эрх”, нийтийн албанд томилогдох эрх”, нийтийн албанд томилогдох, эсхүл сонгогдох эрх” гэсэн өөр өөр нэр томъёог хэрэглэж байна. Үүнийг нэр мөр болгох нь зүйтэй. Энэ хуулийн төсөлд тусгасан зохицуулалтуудад “нийтийн албанд ажиллах эрх” гэх нэр томъёог тусгасан байх тул Эрүүгийн хуульд 14.8 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан “нийтийн албанд томилогдох эрх” гэснийг 23.4 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан “нийтийн албанд томилогдох, эсхүл сонгогдох эрх” гэснийг “нийтийн албанд ажиллах эрх” гэж өөрчлөх нь зүйтэй.

	- Төслийн 18.6 дугаар зүйлийн 3.2-т “виртуал хөрөнгө ашиглаж” гэж тусгасан бөгөөд энэ нь НАТХБХХАНТХ-ийн 4.1.5-д заасан “хөрөнгө” гэх нэр томъёоны тайлбарт тусгагдсан бөгөөд тус хуулийн төслийн дагалдах хуулийн төслийн нэг болох “Түр болон бүр хураан авсан, царцаасан хөрөнгийг эрхлэн удирдах тухай хууль”-ийн төслийн 3.1.1-д заасан “хөрөнгө” гэх нэр томъёоны тайлбарт тусгагдсан “криптовалют” гэх ойлголтоос ялгаатай байна. Өөрөөр хэлбэл, криптовалюта, виртуал хөрөнгө гэх ойлголтуудыг нэгтгэж, тус хуулийн төслүүд тодорхой байдлаар тусгах нь зүйтэй.
Хуулийн төслийн зүйл, заалт нь тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх	- Төслийн 22.10 дугаар зүйлийн тайлбар хэсэгт “...энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан “их хэмжээ” гэдэгт нэг зуун нэгжтэй¹⁴ тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс дээш хэмжээг ойлгоно...” гэж заажээ. Гэтэл Эрүүгийн хуулийн 2.5 дугаар зүйлийн 4.1-д “их хэмжээний хохирол гэж тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс дээш хэмжээг” гэж заажээ. Өөрөөр хэлбэл, хуулийн төслийн тус зохицуулалт нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангид заасан их хэмжээний хохирлын талаарх зохицуулалттай зөрчилдөж байна. Нөгөөтээгүүр, одоогийн практикт хэрэгжиж буй зохицуулалтад ч энэхүү асуудал байгааг дурдах нь зүйтэй. - Монгол Улсын Шүүхийн тухай хуульд шүүгч нөлөөллийн мэдүүлэг хөтлөөгүй бол сахилгын шийтгэл оногдуулахаар заасан бол хуулийн төслийн 22.16 дугаар зүйлд “Шүүгч нөлөөллийн мэдүүлэг хөтлөхгүй байх” нь гэмт хэрэгт тооцохоор хуульчилсан нь өөр хоорондоо зөрчилдөж байна.

¹⁴ Нэг зуун нэгж нь 100.000 төгрөг бөгөөд тус тайлбарын “нэг зуун нэгжтэй” гэсэн нь “нэг зуун **мянган** нэгжтэй” гэсэн утга бүхий зохицуулалт байсныг “мянган” гэх үгийг орхигдуулан бичсэн гэж үзсэн болно. Тус асуудлын “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд тусгасан болно.

ДӨРӨВ.ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын дагуу үнэлгээ хийв.

Ийнхүү үнэлэхдээ уг хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан аргачлалд заасан “Зорилгод хүрэх байдал”, “Практикт хэрэгжих боломж”, “Ойлгомжтой байдал”, “Харилцан уялдаа” гэсэн 4 шалгуур үзүүлэлтийн хүрээнд төслийн үр нөлөөг үнэллээ.

ЭХНӨТХ-ийн төсөл нь Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураах, нөхөн төлүүлэх тухай анхдагч хуулийн төслийн дагалдах 9 хуулийн төслийн нэг бөгөөд судалгааны баг ЭХНӨТХ-ийн төслийн анхдагч хуулийн төслөөс тусад нь үнэлэх шаардлагатай гэж үзсэн болно.

Энэхүү судалгаагаар ЭХНӨТХ-ийн төсөлд тусгасан гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой зохицуулалт /Төслийн 1.10 дугаар зүйлийн 11 дэх хэсэг/, Шүүгч нөлөөллийн мэдүүлэг хөтлөхгүй байх /Төслийн 22.16 дугаар зүйл/ гэмт хэргийн зохицуулалт Эрүүгийн хууль болон Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх тухай хуулийн төслийн **зорилгод хүрч байгаа эсэх**, Мөнгө угаах гэмт хэргийн зохицуулалт /Төслийн 18.6 дугаар зүйл/, Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгийг авах, борлуулах /Төслийн 17.13 дугаар зүйл/ гэмт хэргийн зохицуулалт **практикт хэрэгжих боломжтой эсэх**, хуулийн төслийг бүхэлд нь **ойлгомжтой байдал** болон **харилцан уялдаатай эсэх** шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлж, дараах дүгнэлт хүрч байна.

Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

1. ЭХНӨТХ-ийн төсөлд 1.10 дугаар зүйлийн 11 дэх хэсэгт “Хууль бусаар хөрөнгөжих, мөнгө угаах гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа гэмт хэрэг үйлдсэн өдрөөс хойш хорин жил байна” гэж заажээ.

Төслийн 22.10 дугаар зүйлд заасан “Хууль бусаар хөрөнгөжих” гэмт хэрэгт “нийтийн албан тушаалтан хууль ёсны орлогоосоо их хэмжээгээр давсан хөрөнгө, орлогоо хууль ёсны болохыг үндэслэлтэйгээр тайлбарлаж чадаагүй” бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр тусгасан байна. Гэтэл тус гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг 20 жил байхаар хуульчилсны улмаас тухайн хүн хууль ёсны дагуу олж авсан хөрөнгийг хууль ёсны болохыг нотлох боломжгүй нөхцөл байдал үүсэж, хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах нөхцөлийг бүрдүүлэх эрсдэлийг бий болгож байна гэж үзэж болох юм.

Түүнчлэн, Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйлд заасан гэмт хэрэг үйлдсэн болохыг 20 жилийн хугацаанд тогтоож, яллагдагчаар татах асуудал яригдаж байгаа нь маш урт хугацааны асуудал болж байна.

Мөн Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйлд заасан гэмт хэргээс илүү нийгмийн хор аюулын шинжтэй авлигын гэмт хэрэг тухайлбал, Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тус зохицуулалтад тусгаагүй хэр нь 22.10 дугаар зүйлийг л авлигын гэмт хэргүүдээс хөөн хэлэлцэх хугацаа 20 жил байхаар хуульчилж байгаа нь учир дутагдалтай байна.



Иймд хуулийн төслийн 1.10 дугаар зүйлийн 11 дэх хэсэгт заасан гэмт хэсэгт заасан гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой зохицуулалт зорилгодоо бүрэн хүрсэн гэж дүгнэх боломжгүй байна.

2. Төслийн 22.16 дугаар зүйлд “Шүүгч нөлөөллийн мэдүүлэг хөтлөхгүй байх” гэмт хэргийг Эрүүгийн хуульд шинээр хуульчлахаар тусгажээ.

Монгол Улсын Шүүхийн тухай хуульд зааснаар шүүгч нөлөөллийн мэдүүлэг хөтлөх үүрэгтэй бөгөөд тус үүргээ биелүүлээгүй шүүгчид сахилгын шийтгэл оногдуулахаар байна.

Гэтэл дээрх үйлдлийг хуулийн төслийн 22.16 дугаар зүйлд “Шүүгч нөлөөллийн мэдүүлэг хөтлөхгүй байх” гэмт хэрэгт тооцохоор хуульчилсан байна. Өөрөөр хэлбэл, хуулийн төсөлд шүүгч нөлөөллийн мэдүүлэг хөтлөөгүй бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр тусгасан нь Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн зохицуулалттай зөрчилдөж байна. Иймд хууль хоорондын харилцан уялдааг хангах зайлшгүй шаардлагатай болох нь харагдаж байна.

Нөгөөтээгүүр, төсөлд “Шүүгч нөлөөллийн мэдүүлэг хөтлөхгүй байх” гэмт хэргийг Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан “Авлигын гэмт хэрэг”-т хамааруулан 22.16 дугаар зүйлд тусгахаар зохицуулсан нь оновчтой эсэх асуудал хөндөгдөж байна.

Иймд төслийн тус зохицуулалтыг зорилгодоо бүрэн хүрээгүй байна.

Практик хэрэгжих боломж шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

1. Төслийн 18.6 дугаар зүйлд “Мөнгө угаах” гэмт хэргийн өөрчлөн найруулахаар тусгасан байна.

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль хэрэгжиж эхэлснээс хойш өнөөдрийг хүртэл маргаан дагуулсаар байгаа эрх зүйн хийдэл бүхий зохицуулалтын нэг нь Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйлд заасан “Мөнгө угаах” гэмт хэрэг юм. Учир нь Эрүүгийн хуульд тус гэмт хэргийн бүрэлдэхүүн, шинжийг зөв, ойлгомжтой байдлаар тодорхойлоогүйн улмаас практикт энэхүү зохицуулалт үндсэн шийдвэрлэх асуудлаасаа илүүтэй ахуйн хүрээний жижиг харилцааг зохицуулсан зохицуулалт болон хувираад байна.

Энэхүү эрх зүйн хийдлийг арилгах үүднээс тус хуулийн төсөлд “Мөнгө угаах”, “Гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгийг авах, борлуулах” гэмт хэргийг тусад нь ялган зааглаж тусгасан байна

Гэсэн хэдий ч төслийн 18.6 дугаар зүйлд “Мөнгө угаах” гэмт хэргийг зохицуулахдаа тухайлбал, хорих ялын доод хэмжээ хоёр жилээс дээш хугацаагаар тогтоосон зарим гэмт хэргийн ахуйн шинжтэй байгааг харгалзан үзэх нь зүйтэй. Учир нь ахуйн шинжтэй гэмт хэргийн мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэрэгт оруулснаар эрх зүйн хийдэлтэй байгаа одоогийн нөхцөл байдал бүрэн засагдахгүй үлдэхээр байна.

Нөгөөтээгүүр, тус зохицуулалтад дурдагдаагүй үлдсэн бүлгүүдэд “Мөнгө угаах” гэмт хэргийн суурь гэмт хэрэг гэж үзэх шаардлагатай гэмт хэргүүд багтсан байна. Энэ мэтчилэн хуулийн төслийн энэхүү зохицуулалтад засаж сайжруулах асуудлууд байна.

Иймд судалгааны үр дүнд хуулийн төслийн дээрх зохицуулалт нь одоогийн Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйлд заасан “Мөнгө угаах” гэмт хэргийн эрх зүйн зохицуулалтын хийдлийг арилгахад чиглэсэн зохицуулалт мөн боловч дээр дурдсан асуудлууд хөндөгдөж байх тул практикт хүндрэлгүй хэрэгжих боломж хязгаарлагдмал гэж үзсэн болно.




2. Төслийн 17.13 дугаар зүйлд “Гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгийг авах, борлуулах”-ийг нэмж, хуульчлахаар тусгасан байна.

Хуулийн төсөлд “Мөнгө угаах”, “Гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгийг авах, борлуулах” гэмт хэргийг тусад нь ялган зааглаж тусгасан нь одоогийн практикт тулгамдаж буй дээрх асуудлыг шийдвэрлэхийг зорьсон зохицуулалт болсон байна

Иймээс төслийн 17.13 дугаар зүйлд заасан “Гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгийг авах, борлуулах” гэмт хэргийн зохицуулалт практикт хэрэгжих боломжтой гэж үзэж байна. Гэсэн хэдий ч хуулийн төслийн тус гэмт хэргийн зохицуулалтыг сайжруулах шаардлагатай. Тухайлбал, хуулийн төслийн 17.13 дугаар зүйлд “Гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгийг авах борлуулах” гэж тусгасан боловч 17.13 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “...Гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгө гэдгийг мэдсээр байж урьдчилан амлалгүйгээр авсан, **хадгалсан**, борлуулсан бол...” гэж заажээ. Өөрөөр хэлбэл, тус гэмт хэрэгт хадгалсан үйлдлийг хамааруулан тооцох эсэхийг тодорхой болгох, мөн гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгө гэдгийг мэдсээр байж хийсэн өөр үйлдлийг энэ гэмт хэрэгт хамааруулан тооцох шаардлагатай эсэхийг судлан үзэх нь зүйтэй.

Ойлгомжтой байдал, харилцан уялдаа шалгуур үзүүлэлтийн хүрээнд судалгааны тус 2 шалгуур үзүүлэлтийг үнэлсэн үнэлгээний хэсэгт тухай бүр дүгнэлт хийж, санал гаргасан учир холбогдох хэсгийн дүгнэлт, саналтай танилцана уу.



Хууль тогтоомж, эрх зүйн акт

- Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (1992), №1;
- Авилгалын эсрэг НҮБ-ын конвенц
- Монгол Улсын Шүүхийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2021), №5;
- Эрүүгийн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2002), №5;
- Эрүүгийн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2016), №7;
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2017), №23;

Ном, сурах бичиг, судалгааны тайлан, эмхэтгэл

- Б.Өнөрмаа, Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн зохицуулалт нийтлэл, 2017 он;
- Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, ХЭҮК, 2023 он;
- Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх тухай анхдагч хуулийн төслийн танилцуулга, ХЗДХЯ, 2024 он;
- Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх тухай анхдагч хуулийн төслийн үзэл баримтлал, ХЗДХЯ, 2024 он;
- Х.Сэлэнгэ, Авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа: Онол, практикийн асуудал, 2024 он;
- Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулга, ХЗДХЯ, 2022 он;